



САНХҮҮГИЙН
ЗОХИЦУУЛАХ ХОРОО

ДААТГАЛЫН САЛБАРЫН
2025 ОНЫ 1 ДҮГЭЭР УЛИРЛЫН
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ
НЭГДСЭН ТАЙЛАН

Улаанбаатар хот 2025 он



Хүснэгтийн жагсаалт	3
Дүрслэлийн жагсаалт	4
хүснэгтийн жагсаалт	4
1. Даатгалын хөгжлийн үзүүлэлт	5
даатгалын гүнзгийрэлт	5
2. Даатгалын салбарын ерөнхий мэдээлэл	6
2.1. Тусгай зөвшөөрөл, зөвшөөрөл, бүртгэл, эрхийн мэдээлэл	6
2.2. Даатгагчийн хөрөнгө	7
2.3 даатгагчийн өр төлбөр ба эздийн өмч	10
2.4. Даатгалын хураамж	12
2.5. Даатгагчийн баталгаа	16
2.6. Даатгалын нөхөн төлбөр	17
2.7. Даатгалын харьцаа	19
2.8. Ашигт ажиллагаа	20
3. Ердийн даатгал	23
3.1. Ердийн даатгагчдын хөрөнгө	23
3.2. Ердийн даатгагчдын өр төлбөр ба эздийн өмчийн дүн	24
3.3. Нөөц сан	25
3.4. Ердийн даатгалын хураамж	25
3.5. Ердийн даатгалын нөхөн төлбөр	28
4. Урт хугацааны даатгал	31
4.1. Урт хугацааны даатгагчдын хөрөнгө	31
4.2. Урт хугацааны даатгалын хураамж	32
4.3. Урт хугацааны даатгалын нөхөн төлбөр	33
5. Давхар даатгал	33
6. Албан журмын даатгал	35
7. Даатгалын мэргэжлийн оролцогч	37
7.1. Даатгалын зуучлагч	37
7.2. Даатгалын хохирол үнэлэгч	40
7.3. Даатгалын төлөөлөгч	42

ХҮСНЭГТИЙН ЖАГСААЛТ

- Хүснэгт №1. Даатгалын гүнзгийрэлтийн түвшин
- Хүснэгт №2. Бүртгэл, зөвшөөрлийн ерөнхий мэдээлэл
- Хүснэгт №3. Даатгагчдын хөрөнгө /ангилал тус бүрээр/
- Хүснэгт №4. Даатгагчдын өр төлбөр ба эздийн өмч /ангилал тус бүрээр/
- Хүснэгт №5. Даатгалын нийт хураамжийн орлого
- Хүснэгт №6. Цахим даатгалын борлуулалт
- Хүснэгт №7. Даатгагчийн баталгаа компани тус бүрээр
- Хүснэгт №8. Даатгагчийн баталгааны төрлөөр
- Хүснэгт №9. Даатгалын нөхөн төлбөр
- Хүснэгт №10. Даатгалын харьцаа
- Хүснэгт №11. Даатгагчийн ашигт ажиллагаа
- Хүснэгт №12. Давхар даатгалын хураамж
- Хүснэгт №13. Ердийн даатгагчдын хөрөнгө /ангилал тус бүрээр/
- Хүснэгт №14. Ердийн даатгагчдын өр төлбөр ба эздийн өмчийн дүн
- Хүснэгт №15. Ердийн даатгагчдын нөөц сан
- Хүснэгт №16. Ердийн даатгалын хураамж
- Хүснэгт №17. Ердийн даатгалын хураамж /даатгалын хэлбэрээр/
- Хүснэгт №18. Ердийн даатгалын нөхөн төлбөр
- Хүснэгт №19. Ердийн даатгалын нөхөн төлбөр /даатгалын хэлбэрээр/
- Хүснэгт №20. Урт хугацааны даатгагчдын хөрөнгө /ангилал тус бүрээр/
- Хүснэгт №21. Урт хугацааны даатгалын хураамж
- Хүснэгт №22. Урт хугацааны даатгалын нөхөн төлбөр
- Хүснэгт №23. Давхар даатгалын хураамж, нөхөн төлбөр
- Хүснэгт №24. ЖХАЖД-ын хураамж, нөхөн төлбөр /2019.І-2023.І/
- Хүснэгт №25. ЖХАЖД-ын хураамж, нөхөн төлбөр, хохирлын харьцаа
- Хүснэгт №26. Даатгалын зуучлалын дэлгэрэнгүй

4 | Даатгалын салбарын 2025 оны 1 дүгээр улирлын үйл ажиллагааны нэгдсэн тайлан

Хүснэгт №27. Зуучилсан даатгалын хураамж, зуучлалын шимтгэл

Хүснэгт №28. Даатгалын хохирол үнэлгээ /даатгалын хэлбэрээр/

Хүснэгт №29. Даатгалын хохирол үнэлгээ /компани тус бүрээр/

Хүснэгт №30. Даатгалын төлөөлөгчөөр дамжин орсон даатгалын нийт хураамж

Хүснэгт №31. Даатгалын төлөөлөгчийн шимтгэл

ДҮРСЛЭЛИЙН ЖАГСААЛТ

Дүрслэл №1. Даатгалын гүнзгийрэлтийн түвшин

Дүрслэл №2. Даатгалын болон давхар даатгалын компаниудын нийт хөрөнгө

Дүрслэл №3. Даатгалын компаниудын нийт хөрөнгөд эзлэх хувь

Дүрслэл №4. Хөрөнгө оруулалтын ангилал

Дүрслэл №5. Даатгагчдын нийт өр төлбөр ба эздийн өмч

Дүрслэл №6. Даатгагчдын өр төлбөр ба эздийн өмч /ангилал тус бүрээр/

Дүрслэл № 7. Даатгалын компаниудын нөөц сангийн дүн /сая.төг/

Дүрслэл №8. Даатгалын хураамжийн орлого /өсөлтийн хувиар/

Дүрслэл №9. Даатгалын хураамжийн орлого /эзлэх хувиар/

Дүрслэл №10. Даатгалын хураамж /борлуулалтын сувгаар/

Дүрслэл №11. Даатгалын нөхөн төлбөр /өсөлтийн хувиар/

Дүрслэл №12. Даатгалын компаниудын нөхөн төлбөр /эзлэх хувиар/

Дүрслэл №13. Ердийн даатгагчдын хөрөнгийн ангилал /эзлэх хувиар/

Дүрслэл №14. Ердийн даатгалын хураамжийн орлогод эзлэх хувь /даатгалын хэлбэр/

Дүрслэл №15. Ердийн даатгалын нөхөн төлбөрийн эзлэх хувь /даатгалын хэлбэрээр/

Дүрслэл №16. Зуучилсан даатгалын хураамжийн орлогын эзлэх хувь /даатгалын хэлбэрээр/

Дүрслэл №17. Зуучилсан даатгалын хураамж, зуучлалын шимтгэл /сая.төг/

Дүрслэл №18. Даатгалын нийт хохирол үнэлгээ /эзлэх хувь/

Дүрслэл №19. Даатгалын төлөөлөгчийн даатгалын нийт хураамж бүрдүүлэлтийн эзлэх хувь /даатгалын хэлбэрээр/

1. ДААТГАЛЫН ХӨГЖЛИЙН ҮЗҮҮЛЭЛТ

ДААТГАЛЫН ГҮНЗГИЙРЭЛТ


2025 оны 1 дүгээр улирлын байдлаар Монгол Улсын даатгалын гүнзгийрэлтийн түвшин өмнөх оны мөн үеэс 0.7 функтээр өсч **0.58%**-д хүрсэн байна. /Хүснэгт №1 болон Дүрслэл №1-д тус тус дэлгэрэнгүй харуулав/

Хүснэгт №1. Даатгалын гүнзгийрэлтийн түвшин

Он	Даатгалын нийт хураамжийн орлого /сая.төг/				ДНБ ¹ /сая.төг/	Монгол улсын гүнзгийрэлт
	Ердийн даатгал	Урт хугацааны даатгал	Давхар даатгал	Нийт		
2018.I	34,952.4	380.2	2.8	35,335.5	6,758,521.9	0.52%
2019.I	37,892.3	417.6	25.3	38,335.2	8,431,243.5	0.45%
2020.I	40,305.3	370.4	801.3	41,477.0	9,404,825.0	0.44%
2021.I	38,430.1	526.4	835.9	39,792.4	10,512,325.4	0.38%
2022.I	49,898.2	552.1	855.1	51,305.4	9,555,002.1	0.54%
2023.I	73,466.6	1,232.7	1,471.3	76,170.6	17,633,322.6	0.43%
2024.I	106,907.9	848.6	2,261.9	110,018.3	21,715,753.1	0.51%
2025.I	106,163.9	1,852.5	2,016.4	110,032.8	18,968,465.6	0.58%

* Даатгалын гүнзгийрэлт гэж даатгалын нийт хураамжийн орлогыг Дотоодын нийт бүтээгдэхүүнд харьцуулсан харьцаа

Дүрслэл №1. Даатгалын гүнзгийрэлтийн түвшин



¹ <https://www.1212.mn/mn>

2. ДААТГАЛЫН САЛБАРЫН ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ

2.1. ТУСГАЙ ЗӨВШӨӨРӨЛ, ЗӨВШӨӨРӨЛ, БҮРТГЭЛ, ЭРХИЙН МЭДЭЭЛЭЛ

10.9%

Салбарын хувьцаа эзэмшигчдийн тоо 10.9%-аар өсөв

2025 оны 1 дүгээр улирлын байдлаар Хорооноос тусгай зөвшөөрөлтэйгээр 20 даатгалын компани, үүнээс 17 ердийн даатгалын компани, 2 урт хугацааны даатгалын компани, 1 давхар даатгалын компани, мөн 62 даатгалын зуучлагч компани, үүнээс 9 даатгалын зуучлагч банк болон 29 даатгалын хохирол үнэлэгч, 2622 даатгалын төлөөлөгч тус тус үйл ажиллагаа эрхлэн явуулж байна. Мөн 47 аудитын компанийн 151 аудитор, 40 актуарч тус тус Хорооноос олгосон эрхийн дагуу даатгалын салбарт үйл ажиллагаа эрхэлж байна. /Хүснэгт №2-т дэлгэрэнгүй харуулав/

Хүснэгт №2. Бүртгэл, зөвшөөрлийн ерөнхий мэдээлэл

№	Ерөнхий мэдээлэл	2024.I	2025.I	Ө/Б
1	Даатгалын компанийн тоо	18	20	11.1%
	Ердийн даатгал:	15	17	13.3%
	Үүнээс гадаадын хөрөнгө оруулалттай	2	2	0.0%
	Урт хугацааны даатгалын компани	2	2	0.0%
	Үүнээс гадаадын хөрөнгө оруулалттай	1	1	0.0%
	Давхар даатгалын компани	1	1	0.0%
2	Даатгалын зуучлагч компани	63	62	-1.6%
	Үүнээс: банк-зуучлагч	10	9	-10.0%
	давхар даатгалын зуучлагч	11	11	0.0%
3	Даатгалын хохирол үнэлэгч компани	24	29	20.8%
4	Даатгалын төлөөлөгч	2457	2622	6.7%
	Үүнээс: Компани	6	6	0.0%
	Хотод ажиллах төлөөлөгч	634	757	19.4%
5	Салбарын тоо	690	689	-0.1%
	Үүнээс Даатгалын компанийн	239	237	-0.8%
	Үүнээс УБ-т	40	40	0.0%
	Даатгалын зуучлагчийн	406	406	0.0%
	Ердийн болон давхар даатгалын зуучлагчийн салбар	112	118	5.4%
	үүнээс УБ-т	30	36	20.0%
	банк-зуучлагчийн салбар	294	288	-2.0%
	үүнээс УБ-т	186	181	-2.7%
	Даатгалын хохирол үнэлэгчийн	45	46	2.2%
үүнээс УБ-т	30	31	3.3%	
6	Төлөөлөгчийн газрын тоо	57	61	7.0%
	Үүнээс Даатгалын компанийн	14	15	7.1%

7 | Даатгалын салбарын 2025 оны 1 дүгээр улирлын үйл ажиллагааны нэгдсэн тайлан

	үүнээс УБ-т	4	4	0.0%
	гадаад	2	2	0.0%
	Даатгалын зуучлагчийн	0	0	-
	Үүнээс: банк-зуучлагчийн	0	0	-
	Даатгалын хохирол үнэлэгчийн	43	46	7.0%
	үүнээс УБ-т	11	13	18.2%
7	Даатгалын бүтээгдэхүүний тоо	713	771	8.1%
8	Эрх бүхий албан тушаалтны тоо	332	354	6.6%
	Үүнээс: даатгалын компанийн	175	191	9.1%
	үүнээс: ТУЗ	141	151	7.0%
	даатгалын зуучлагчийн	110	107	-2.7%
	даатгалын хохирол үнэлэгчийн	47	56	19.1%
9	Аудитын компанийн тоо	45	47	4.4%
	Аудиторын тоо	147	151	2.7%
10	Даатгалын байгууллагын хувьцаа эзэмшигчдийн тоо	22960	25464	10.9%
	Даатгалын компанийн	22801	25304	11.0%
	Үүнээс: ХХК-ийн хувьд	44	84	90.9%
	нээлттэй ХК-ийн хувьд	22757	25220	10.8%
	Хуулийн этгээд	26	29	11.5%
	Даатгалын зуучлагчийн	114	108	-5.3%
	Даатгалын хохирол үнэлэгчийн	45	52	15.6%
11	Актварчийн тоо /Хорооноос эрх олгосон/	40	40	0.0%

Даатгалын байгууллагын хувьцаа эзэмшигчдийн тоо өмнөх оны мөн үеэс 10.9 хувиар өссөн байна.

Мөн даатгалын бүтээгдэхүүний тоо өмнөх оны мөн үеэс 8.1 хувиар өсч 771-т хүрсэн нь даатгалын салбарын бүтээгдэхүүн, үйлчилгээний хүртээмж нэмэгдэж буйг харуулж байна.

2.2. ДААТГАГЧИЙН ХӨРӨНГӨ

16.0%

Даатгагчдын нийт хөрөнгө 675.6 тэрбум төгрөгт хүрч өмнөх оны мөн үеэс 16.0 хувиар өссөн байна.

Даатгалын компаниудын нийт хөрөнгө 2025 оны 1 дүгээр улирлын байдлаар 675.6 тэрбум төгрөгт хүрсэн ба өмнөх оны мөн үеэс 16.0 хувиар өссөн байна. Мөн тайлант үеийг 2021 оны 1 дүгээр улиралтай харьцуулбал нийт хөрөнгө 68.3 хувиар өссөн бол даатгагчдын хөрөнгө оруулалтын дүн 66.7 хувиар өссөн байна. /Хүснэгт №3, Дүрслэл №2-т тус тус дэлгэрэнгүй харуулав/

Хүснэгт №3. Даатгагчдын хөрөнгө /ангилал тус бүрээр/

Он	Хөрөнгийн ангилал	Нийт	Нийт дүнгээр /сая.төг/			Эзлэх хувь /%/		
			Ердийн	Урт	Давхар	Ердийн	Урт	Давхар
2021.I	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн дүн	15,032.3	13,635.2	96.6	1,300.5	90.7%	0.6%	8.7%
	Даатгалын авлагын дүн	28,237.5	27,168.8	0.7	1,068.0	96.2%	0.0%	3.8%

8 | Даатгалын салбарын 2025 оны 1 дүгээр улирлын үйл ажиллагааны нэгдсэн тайлан

	Хөрөнгө оруулалтын дүн	247,318.0	187,160.7	7,355.1	52,802.1	75.7%	3.0%	21.3%
	Үндсэн хөрөнгө /Цэвэр/	32,232.2	29,331.3	2,315.7	585.2	91.0%	7.2%	1.8%
	Биет бус хөрөнгө /Цэвэр/	1,045.3	531.6	24.5	489.1	50.9%	2.3%	46.8%
	бусад	77,335.2	76,178.1	272.8	884.4	98.5%	0.4%	1.1%
	нийт хөрөнгийн дүн	401,200.5	334,005.7	10,065.5	57,129.4	83.3%	2.5%	14.2%
2022.I	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн дүн	20,939.1	19,369.7	448.7	1,120.7	92.5%	2.1%	5.4%
	Даатгалын авлагын дүн	31,966.5	31,044.4	44.6	877.5	97.1%	0.1%	2.7%
	Хөрөнгө оруулалтын дүн	252,904.1	190,437.9	6,521.3	55,944.9	75.3%	2.6%	22.1%
	Үндсэн хөрөнгө /Цэвэр/	30,420.4	27,836.1	2,206.8	377.5	91.5%	7.3%	1.2%
	Биет бус хөрөнгө /Цэвэр/	933.7	523.7	10.2	399.8	56.1%	1.1%	42.8%
	Бусад	81,292.8	80,097.1	273.3	922.4	98.5%	0.3%	1.1%
	нийт хөрөнгийн дүн	418,456.6	349,309.0	9,504.8	59,642.8	83.5%	2.3%	14.3%
2023.I	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн дүн	24,928.3	21,942.7	780.9	2,204.7	88.0%	3.1%	8.8%
	Даатгалын авлагын дүн	48,913.1	46,963.6	676.7	1,272.8	96.0%	1.4%	2.6%
	Хөрөнгө оруулалтын дүн	286,563.4	215,433.8	13,642.5	57,487.1	75.2%	4.8%	20.1%
	Үндсэн хөрөнгө /Цэвэр/	30,273.7	29,763.7	109.3	400.7	98.3%	0.4%	1.3%
	Биет бус хөрөнгө /Цэвэр/	2,803.7	2,429.6	66.1	308.0	86.7%	2.4%	11.0%
	Бусад	93,456.2	89,926.6	1,686.0	1,843.5	96.2%	1.8%	2.0%
	нийт хөрөнгийн дүн	486,938.3	406,459.9	16,961.6	63,516.8	83.5%	3.5%	13.0%
2024.I	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн дүн	27,872.0	24,471.9	1,263.6	2,136.5	87.8%	4.5%	7.7%
	Даатгалын авлагын дүн	55,241.5	52,479.8	91.8	2,669.9	95.0%	0.2%	4.8%
	Хөрөнгө оруулалтын дүн	341,301.2	266,950.5	13,344.5	61,006.2	78.2%	3.9%	17.9%
	Үндсэн хөрөнгө /Цэвэр/	38,936.5	36,875.8	1,791.1	269.6	94.7%	4.6%	0.7%
	Биет бус хөрөнгө /Цэвэр/	7,575.7	7,309.4	30.3	236.1	96.5%	0.4%	3.1%
	Бусад	111,348.9	108,603.1	655.3	2,090.4	97.5%	0.6%	1.9%
	нийт хөрөнгийн дүн	582,275.8	496,690.5	17,176.5	68,408.7	85.3%	2.9%	11.7%
2025.I	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн дүн	22,317.5	19,758.8	831.3	1,727.4	88.5%	3.7%	7.7%
	Даатгалын авлагын дүн	51,843.7	49,883.3	124.4	1,836.0	96.2%	0.2%	3.5%
	Хөрөнгө оруулалтын дүн	412,395.2	339,520.0	13,729.4	59,145.8	82.3%	3.3%	14.3%
	Үндсэн хөрөнгө /Цэвэр/	50,637.0	47,001.9	2,812.7	822.4	92.8%	5.6%	1.6%
	Биет бус хөрөнгө /Цэвэр/	6,737.2	6,676.1	57.0	4.1	99.1%	0.8%	0.1%
	Бусад	131,620.7	128,229.2	716.6	2,674.9	97.4%	0.5%	2.0%
	нийт хөрөнгийн дүн	675,551.3	591,069.3	18,271.5	66,210.5	87.5%	2.7%	9.8%


Дүрслэл №2. Даатгалын болон давхар даатгалын компаниудын нийт хөрөнгө

9 | Даатгалын салбарын 2025 оны 1 дүгээр улирлын үйл ажиллагааны нэгдсэн тайлан



Даатгалын компаниудын нийт хөрөнгөд эзлэх хувийг даатгагчийн төрлөөр авч үзвэл ердийн даатгалын компаниудын нийт хөрөнгө 591.1 тэрбум төгрөг буюу нийт даатгагчдын хөрөнгийн 87.5 хувийг, урт хугацааны даатгалын компаниудын нийт хөрөнгө 18.3 тэрбум төгрөг буюу нийт даатгагчдын хөрөнгийн 2.7 хувийг, давхар даатгалын компанийн хөрөнгө 66.2 тэрбум төгрөг буюу нийт даатгагчдын хөрөнгийн 9.8 хувийг тус тус эзэлж байна. /Дүрслэл №3-т дэлгэрэнгүй харуулав/


Дүрслэл №3. Даатгалын компаниудын нийт хөрөнгөд эзлэх хувь



Даатгагчдын хөрөнгө оруулалтыг өмнөх оны мөн үетэй харьцуулан авч үзвэл хадгаламж, хадгаламжийн сертификатад оруулах хөрөнгө оруулалт 5.1 хувиар өссөн бол үнэт цаасанд оруулж буй хөрөнгө оруулалт 10.2 хувиар буурсан байна. Харин тайлант үеийг 2021 оны мөн үетэй харьцуулбал даатгагчдын үнэт цаасанд оруулж буй хөрөнгө оруулалт 4.5 дахин өссөн үзүүлэлттэй байна. /Дүрслэл №4-д дэлгэрэнгүй харуулав/

Дүрслэл №4. Хөрөнгө оруулалтын ангилал

10 | Даатгалын салбарын 2025 оны 1 дүгээр улирлын үйл ажиллагааны нэгдсэн тайлан



2.3 ДААТГАГЧИЙН ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧ

17.1%

Даатгагчдын нөөц сангийн дүн **320.3 тэрбум төгрөгт** хүрч, өмнөх оны мөн үеэс **17.1 хувиар** өсөв.

2025 оны 1 дүгээр улирлын байдлаар нийт өр төлбөрт ердийн даатгагчид 83.3 хувь, урт хугацааны даатгагчид 4.4 хувь, давхар даатгагч 12.3 хувийг тус тус эзэлж байна. Мөн эздийн өмчийн дүнгийн дийлэнх хувийг ердийн даатгагчид эзэлж байна. 2021 оны 1 дүгээр улиралд даатгагчдын нөөц сангийн дүн 172.6 тэрбум.төг байсан бол тайлант хугацаанд 1.8 дахин өсч 320.3 тэрбум төгрөгт хүрсэн байна. Энэ нь даатгалын нийт хураамжийн орлого 2021 оны мөн үетэй харьцуулахад 3 дахин өссөнтэй холбоотой юм. /Хүснэгт №4, Дүрслэл №5-д дэлгэрэнгүй харуулав/


Хүснэгт №4. Даатгагчдын өр төлбөр ба эздийн өмч /ангилал тус бүрээр/

Он	Хөрөнгийн ангилал	Нийт	Нийт дүнгээр /сая.төг/			Эзлэх хувь /%/		
			Ердийн	Урт	Давхар	Ердийн	Урт	Давхар
2021.I	Даатгалын өглөгийн дүн	17,355.7	16,980.8	12.0	363.0	97.8%	0.1%	2.1%
	Бусад санхүүгийн өр төлбөрийн дүн	10,226.2	9,832.5	0.0	393.7	96.1%	0.0%	3.9%
	Нөөц сангийн дүн	172,618.2	142,687.5	3,025.7	26,905.1	82.7%	1.8%	15.6%
	Нийт өр төлбөрийн дүн	207,993.8	176,680.9	3,089.8	28,223.2	84.9%	1.5%	13.6%
	Эздийн өмчийн дүн	193,260.0	157,378.1	6,975.7	28,906.2	81.4%	3.6%	15.0%
2022.I	Даатгалын өглөгийн дүн	18,138.9	17,700.5	13.0	425.5	97.6%	0.1%	2.3%
	Бусад санхүүгийн өр төлбөрийн дүн	9,117.9	9,069.3	0.0	48.5	99.5%	0.0%	0.5%
	Нөөц сангийн дүн	178,152.6	149,771.1	2,505.6	27,566.7	84.1%	1.4%	15.5%
	Нийт өр төлбөрийн дүн	215,052.8	183,823.7	2,586.4	28,642.7	85.5%	1.2%	13.3%
	Эздийн өмчийн дүн	203,403.7	165,485.3	6,918.4	31,000.1	81.4%	3.4%	15.2%
2023.I	Даатгалын өглөгийн дүн	27,449.9	26,801.5	11.3	637.0	97.6%	0.0%	2.3%

11 | Даатгалын салбарын 2025 оны 1 дүгээр улирлын үйл ажиллагааны нэгдсэн тайлан


	Бусад санхүүгийн өр төлбөрийн дүн	14,189.5	13,879.4	5.2	304.9	97.8%	0.0%	2.1%
	Нөөц сангийн дүн	217,434.2	184,322.7	3,360.1	31,858.4	84.8%	1.5%	14.7%
	Нийт өр төлбөрийн дүн	271,686.4	234,100.2	3,450.3	34,135.9	86.2%	1.3%	12.6%
	Эздийн өмчийн дүн	215,251.9	172,359.8	13,511.2	29,380.9	80.1%	6.3%	13.6%
2024.I	Даатгалын өглөгийн дүн	37,414.1	36,608.5	42.2	763.4	97.8%	0.1%	2.0%
	Бусад санхүүгийн өр төлбөрийн дүн	16,559.3	16,401.6	4.9	152.8	99.0%	0.0%	0.9%
	Нөөц сангийн дүн	273,423.2	239,026.5	3,335.8	31,060.9	87.4%	1.2%	11.4%
	Нийт өр төлбөрийн дүн	339,309.5	301,569.2	4,557.0	33,183.3	88.9%	1.3%	9.8%
	Эздийн өмчийн дүн	242,966.3	195,121.3	12,619.6	35,225.4	80.3%	5.2%	14.5%
2025.I	Даатгалын өглөгийн дүн	30,060.4	28,992.9	72.7	994.8	96.4%	0.2%	3.3%
	Бусад санхүүгийн өр төлбөрийн дүн	35,169.9	34,071.9	341.9	756.0	96.9%	1.0%	2.1%
	Нөөц сангийн дүн	320,255.4	285,558.1	5,261.0	29,436.3	89.2%	1.6%	9.2%
	Нийт өр төлбөрийн дүн	398,996.6	360,655.7	6,181.0	32,159.8	90.4%	1.5%	8.1%
	Эздийн өмчийн дүн	276,554.7	230,413.6	12,090.5	34,050.7	83.3%	4.4%	12.3%

Дүрслэл №5. Даатгагчдын нийт өр төлбөр ба эздийн өмч




Даатгагчдын нийт өр төлбөрийн дийлэнх хувийг буюу 80 гаруй хувийг даатгалын нөөц сан эзэлж байна. Тайлант хугацаанд даатгагчдын нөөц сан 320.3 тэрбум төгрөг, эздийн өмч 276.6 тэрбум төгрөгт хүрсэн байна. /Дүрслэл №6-д дэлгэрэнгүй харуулав/

Дүрслэл №6. Даатгагчдын өр төлбөр ба эздийн өмч /ангилал тус бүрээр/



Өмнөх оны мөн үетэй харьцуулахад тайлант хугацаанд урт хугацааны даатгалын нөөц сан 57.7 хувиар, ердийн даатгалын нөөц сан 19.5 хувиар тус тус өссөн бол давхар даатгагчийн нөөц сан 5.2 хувиар буурсан байна. /Дүрслэл №7-д дэлгэрэнгүй харуулав/

Дүрслэл № 7. Даатгалын компаниудын нөөц сангийн дүн /сая.төг/



2.4. ДААТГАЛЫН ХУРААМЖ

110.0₮

Даатгалын болон давхар даатгалын нийт хураамжийн орлого 110.0 тэрбум төгрөгт хүрэв.

2025 оны 1 дүгээр улирлын байдлаар даатгалын болон давхар даатгалын нийт хураамжийн орлого 110.0 тэрбум төгрөгт хүрсэн бөгөөд үүнээс ердийн даатгалын нийт хураамжийн орлого 106.2 тэрбум төгрөг, урт хугацааны даатгалын нийт хураамжийн орлого 1.8 тэрбум төгрөг, давхар даатгалын хураамжийн орлого 2.0 тэрбум төгрөгт байна. Тайлант хугацаанд ердийн болон урт хугацааны даатгалын компаниуд нь 134.1 их наяд төгрөгийн үнэлгээ бүхий даатгалын эрсдэлийг хүлээн авсан байна. Үүнээс онцолбол Бодь даатгал ЖК-

13 | Даатгалын салбарын 2025 оны 1 дүгээр улирлын үйл ажиллагааны нэгдсэн тайлан


ийн даатгалын нийт хураамжийн орлого өмнөх оны мөн үеэс 3 дахин өссөн нь 2.9 наяд бүхий агаарын хөлгийн даатгалын хэлбэрийн эрсдэлийг хүлээн авч 5.5 тэрбум төгрөгийн даатгалын нийт хураамжийн орлоготой ажилласан бол Улаанбаатар хотын даатгал ХХК нь автотээврийн хэрэгслийн даатгалын хэлбэрт түлхүү анхаарал хандуулж өмнөх оны мөн үетэй харьцуулахад 2 дахин их даатгалын нийт хураамжийн орлоготой ажилласан байна. /Хүснэгт №5-д дэлгэрэнгүй харуулав/

Хүснэгт №5. Даатгалын нийт хураамжийн орлого

Даатгалын нийт хураамжийн орлого /сая.төг/						
Даатгалын компаниуд		2021.I	2022.I	2023.I	2024.I	2025.I
Ердийн даатгал	Монре даатгал	1,011.1	2,110.0	2,868.6	1,603.0	2,204.9
	Ард даатгал	2,696.9	3,405.1	5,463.6	10,939.5	8,687.0
	Бодь даатгал	5,647.6	5,275.0	4,533.5	5,669.0	16,360.8
	Мөнх даатгал	1,627.4	2,540.5	3,742.2	5,587.5	7,816.9
	Миг даатгал	4,713.5	6,621.4	9,453.3	13,666.3	14,233.0
	Монгол даатгал	4,717.2	3,796.3	4,206.8	5,547.1	5,319.2
	Тэнгэр даатгал	2,155.0	2,610.1	3,021.1	5,550.0	5,955.9
	Номин даатгал	1,796.7	2,033.6	3,956.0	5,506.9	4,402.0
	Улаанбаатар хотын даатгал	392.6	432.7	390.5	1,782.7	3,542.8
	Амар даатгал	955.9	2,975.8	7,792.3	6,966.2	8,207.4
	Ган зам даатгал	52.2	75.7	90.6	107.0	124.4
	Практикал даатгал	2,348.1	5,436.5	10,183.1	14,934.1	7,157.8
	Мандал даатгал	8,192.7	8,963.2	12,760.7	19,489.3	9,877.5
	Хаан даатгал	2,123.2	3,252.7	3,894.5	6,358.6	9,736.6
	Агула даатгал		369.6	1,109.8	3,200.7	1,700.6
	Иншүрко даатгал				0.0	529.1
	Агис менежмент даатгал					308.1
	Нийт		38,430.1	49,898.2	73,466.6	106,907.9
Урт хугацааны даатгал	Нэйшнл лайф даатгал	526.4	552.1	1,232.7	817.0	955.0
	Мандал лайф даатгал			0.0	31.5	897.5
	Нийт	526.4	552.1	1,232.7	848.6	1,852.5
Урт ба ердийн нийт		38,956.5	50,450.3	74,699.3	107,756.5	108,016.4
Давхар даатгал	Үндэснийд давхар даатгал	835.9	855.1	1,471.3	2,261.9	2,016.4
	Нийт	835.9	855.1	1,471.3	2,261.9	2,016.4
Нийт даатгалын компаниудын		39,792.4	51,305.4	76,170.6	110,018.3	110,032.8


Урт хугацааны даатгалын компанийн хураамжийн орлого өмнөх оны мөн үеэс 2 дахин өссөн бол, ердийн болон давхар даатгагчийн хураамжийн орлого бага хэмжээгээр буурсан байна. Нийт хураамжийн орлогын хувьд өмнөх оны мөн үеэс өөрчлөлт гараагүй байна.

Дүрслэл №8. Даатгалын хураамжийн орлого /өсөлтийн хувиар/




Даатгалын нийт хураамжид урт хугацааны даатгалын хураамжийн орлогын эзлэх хувь 2025 оны 1 дүгээр улиралд 1.8 хувь байгаа хэдий ч сүүлийн 5 жилийн хандлагаар харьцангуй өсөлттэй байна./Дүрслэл №9-т дэлгэрэнгүй харуулав./

Дүрслэл №9. Даатгалын хураамжийн орлого /эзлэх хувиар/



Даатгалын хураамжийн орлого бүрдүүлэлтийг борлуулалтын сувгаар нь авч үзвэл даатгалын нийт хураамжийн орлогын 42.8 хувь нь даатгалын төлөөлөгчөөр, 19.9 хувь нь даатгалын зуучлагч компаниар, банк даатгалын зуучлагч компаниар 14.3 хувь нь дамжин бүрдсэн байна. Даатгалын хэлбэрээр нь авч үзвэл автотээврийн хэрэгслийн даатгалыг даатгалын зуучлагч, төлөөлөгч нар голчлон борлуулсан байх ба уг даатгалын хэлбэрийн хувьд даатгалын нийт хураамжийн 8.8% хувийг даатгалын зуучлагч нар, 17.3 хувийг даатгалын төлөөлөгч нар зуучлан борлуулсан байна. /Дүрслэл №10-т дэлгэрэнгүй харуулав/

Дүрслэл №10. Даатгалын хураамж /борлуулалтын сувгаар/



Цахим даатгалын борлуулалт:

Тайлант хугацаанд нийт 11 даатгалын компани цахим болон аливаа дэвшилтэд технологи ашиглан 478.8 тэрбум төгрөгийн даатгалын үнэлгээ бүхий эрсдэлийг хүлээн авч 6262 даатгалын гэрээ байгуулж 615.0 сая төгрөгийн даатгалын хураамжийн орлоготой ажилласан бол 195 даатгуулагчид 175.5 сая төгрөгийн нөхөн төлбөр олгосон байна. Олон услын чиг хандлагын дагуу манай улсын даатгалын салбарын үйлчилгээнд цахим технологи нэвтэрч эхэлж буйг илтгэж байна. /Хүснэгт №6-д дэлгэрэнгүй харуулав/

Хүснэгт №6. Цахим даатгалын борлуулалт

№	Даатгалын бүтээгдэхүүний нэр	Хэрэгжүүлж буй хэлбэр*	Нийт даатгалын үнэлгээний дүн /сая.төг/	Нийт даатгалын хураамжийн дүн /сая.төг/	Нийт даатгалын гэрээний тоо	Нийт даатгалын нөхөн төлбөрийн дүн /сая.төг/	Нийт даатгалын нөхөн төлбөр авсан даатгуулагчийн тоо
1	Монгол даатгал	Чатбот	7,525.3	6.1	74	5.2	6
2	Ард даатгал	Аппликэйшн	56,782.4	128.8	2,663	108.2	84
3	Бодь даатгал	Вебсайт	12,666.6	11.8	113	0.0	-
4	Тэнгэр даатгал	Вебсайт	64,220.4	61.7	861	13.5	17
5	Номин даатгал	Вебсайт	3,164.4	2.7	31	0.0	-
6	Улаанбаатар хотын даатгал	Вебсайт	250.0	1.3	25	0.0	-
7	Мандал даатгал	Чатбот, Аппликэйшн	326,058.4	377.7	2,269	46.5	86
8	Агула даатгал	Вебсайт	7,125.6	12.3	165	1.9	1
9	Агис менежмент даатгал	Вебсайт	726.5	10.9	26	0.3	1
10	Миг даатгал	Вебсайт	105.0	0.9	18	0.0	-

11	Нэйшнл лайф даатгал	Вебсайт	156.1	0.7	17	0.0	-
Нийт			478,780.5	615.0	6,262	175.5	195

2.5. ДААТГАГЧИЙН БАТАЛГАА



8.4 тэрбум төгрөгийн баталгаа гаргаж 542.0 сая төгрөгийн хураамжийн орлоготой ажиллав.

Даатгагчийн баталгаа нь иргэн, аж ахуйн нэгж байгууллага гэрээгээр хүлээсэн үүргээ даатгалын компанид шилжүүлж, даатгалын компани нь гэрээнд заасан нөхцөлийн дагуу төлбөр төлбөр баталгаа гаргах үйл ажиллагаа бөгөөд тайлант хугацаанд 6 даатгалын компани 8.4 тэрбум төгрөгийн дүнтэй 141 даатгагчийн баталгаа гаргаж 542.0 сая төгрөгийн хураамжтай ажиллав. /Хүснэгт №7, №8/

Хүснэгт №7. Даатгагчийн баталгаа компани тус бүрээр

Даатгалын компани	Баталгааны төрөл	Баталгааны тоо	Баталгааны дүн /сая.төг/	Нийт хураамж /сая.төг/
Амар даатгал	Тендерийн баталгаа	8	115.8	7.7
	Гүйцэтгэлийн баталгаа	3	171.9	12.3
Нийт		11	287.7	20.1
Ард даатгал	Тендерийн баталгаа	40	642.5	40.5
	Гүйцэтгэлийн баталгаа	17	1,033.9	60.5
Нийт		57	1,676.4	101.0
Мөнх даатгал	Тендерийн баталгаа	48	2,477.8	153.5
	Гүйцэтгэлийн баталгаа	6	578.9	60.3
	Чанарын баталгаа	1	63.0	7.7
Нийт		55	3,119.7	221.5
Иншүрко даатгал	Тендерийн баталгаа	4	70.1	4.7
	Гүйцэтгэлийн баталгаа	1	229.5	11.6
	Урьдчилгаа төлбөрийн баталгаа	1	2,295.0	91.9
Нийт		6	2,594.6	108.2
Номин даатгал	Тендерийн баталгаа	9	548.1	33.8
Бодь даатгал	Гүйцэтгэлийн баталгаа	1	111.8	10.9
	Урьдчилгаа төлбөрийн баталгаа	1	18.3	18.0
	Чанарын баталгаа	1	28.8	28.5
Нийт		3	158.9	57.4
Нийт 6 компани		141	8,385.5	542.0

Хүснэгт №8. Даатгагчийн баталгааны төрлөөр

Баталгааны төрөл	Баталгааны тоо	Баталгааны дүн /сая.төг/	Нийт хураамж /сая.төг/
------------------	----------------	--------------------------	------------------------

Гүйцэтгэлийн баталгаа	28	2,126.1	155.7
Урьдчилгаа төлбөрийн баталгаа	2	2,313.3	109.9
Чанарын баталгаа	2	91.8	36.1
Нийт	141	8,385.5	542.0

2.6. ДААТГАЛЫН НӨХӨН ТӨЛБӨР



Даатгалын нөхөн төлбөр 49.1 тэрбум төгрөгт хүрсэн нь өмнөх оны мөн үеэс 37.3 хувиар өссөн.

2025 оны 1 дүгээр улирлын байдлаар нийт даатгалын нөхөн төлбөр 49.1 тэрбум төгрөгт хүрсэн нь өмнөх оны мөн үеэс 37.3 хувиар өссөн байна.

Нийт нөхөн төлбөрийн 97.4 хувийг ердийн даатгалын нөхөн төлбөр эзэлж байна. Мөн онцолбол нийт даатгагчдаас хамгийн их нөхөн төлбөр олгосон даатгалын компани нь “Практикал даатгал” ХХК бөгөөд тус компанийн хувьд 13.0 тэрбум төгрөгийн нөхөн төлбөр олгосон нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 5 дахин өссөн ба нийт нөхөн төлбөрийн 26.4 хувийг эзэлж байна. Үүнээс агаарын хөлгийн даатгалын хэлбэрийн нөхөн төлбөрт 10.1 тэрбум төгрөг олгосон байна. Харин “Мандал лайф даатгал” ХК-ийн хуримтлалын даатгалын хэлбэрийн бүтээгдэхүүний нөхөн төлбөрт 5 даатгалын гэрээнд 600 сая төгрөгийн нөхөн төлбөр олгосон байна. /Хүснэгт №9, Дүрслэл №11, №12-т тус тус дэлгэрэнгүй харуулав/


Хүснэгт №9. Даатгалын нөхөн төлбөр

Даатгалын нөхөн төлбөр /сая.төг/						
Даатгалын компаниуд		2021.I	2022.I	2023.I	2024.I	2025.I
Ердийн даатгал	Монре даатгал	657.5	1,126.4	1,490.2	1,823.0	328.1
	Ард даатгал	892.8	1,496.6	2,537.4	5,424.1	5,353.5
	Бодь даатгал	1,965.1	3,795.6	3,763.6	2,733.1	2,398.3
	Мөнх даатгал	374.7	829.4	1,159.3	2,390.2	2,263.6
	Миг даатгал	1,496.7	2,531.6	4,085.3	4,325.6	5,678.7
	Монгол даатгал	1,748.4	2,079.1	1,954.9	2,534.8	2,100.3
	Тэнгэр даатгал	651.4	997.3	912.6	2,354.3	1,346.1
	Номин даатгал	741.4	5,294.7	1,581.4	2,358.0	2,499.3
	Улаанбаатар хотын даатгал	34.4	31.2	50.4	450.1	1,747.9
	Амар даатгал	263.1	518.2	923.0	1,239.0	1,330.0
	Ган зам даатгал	17.1	271.6	21.6	25.0	15.3
	Практикал даатгал	1,230.8	2,879.4	3,150.3	2,874.1	13,044.7


18 | Даатгалын салбарын 2025 оны 1 дүгээр улирлын үйл ажиллагааны нэгдсэн тайлан

	Мандал даатгал	1,456.7	2,654.4	2,917.9	3,767.8	5,918.4
	Хаан даатгал	598.7	1,415.9	1,260.7	2,135.2	3,458.4
	Агула даатгал		25.7	216.1	863.1	467.1
	Иншүрко даатгал				0.0	5.4
	Агис менежмент даатгал					11.5
	Нийт		12,128.7	25,947.1	26,024.9	35,297.4
Урт хугацааны даатгал	Нэйшнл лайф даатгал	188.2	292.9	492.2	484.9	555.1
	Мандал лайф даатгал			0.0	0.0	600.0
	Нийт	188.2	292.9	492.2	484.9	1,155.1
Урт ба ердийн нийт		12,316.9	26,240.0	26,517.1	35,782.3	49,121.8
Давхар даатгал	Үндэсний давхар даатгал	75.6	42.2	335.0	390.3	104.5
	Нийт	75.6	42.2	335.0	390.3	104.5
Нийт даатгалын компаниудын		12,392.4	26,282.2	26,852.1	36,172.6	49,226.3

Дүрслэл №11. Даатгалын нөхөн төлбөр /өсөлтийн хувиар/



Дүрслэл №12. Даатгалын компаниудын нөхөн төлбөр /эзлэх хувиар/



2.7. ДААТГАЛЫН ХАРЬЦАА



**Ердийн даатгалын
хохирлын харьцаа: 61.6%**

**Урт хугацааны даатгалын
хохирлын харьцаа: 75.6%**



Тайлант хугацаанд хохирлын харьцаа (давхар даатгагчаас төлсөн нөхөн төлбөрийг оруулж тооцсон болно) ердийн даатгалын компаниудын хувьд 61.6 хувь, урт хугацааны даатгалын компанийн хувьд 75.6 хувь байгаа бол хосолсон харьцаа 117.0 хувь болон 132.7 хувьтай байна. Энэ нь тайлант хугацаанд даатгалын компаниудын даатгалын үйл ажиллагааны зардал өндөр байсныг харуулж байна.

Мөн Агис менежмент даатгал ХХК, Үндэсний давхар даатгал ХК-иудын үйл ажиллагааны зардлын дүн маш өндөр байгаагийн улмаас даатгалын хохирлын харьцаа өндөр гарсан байна. /Хүснэгт №10-д дэлгэрэнгүй харуулав/

Хүснэгт №10. Даатгалын харьцаа

№	Ердийн даатгал					
	Даатгалын компани	Орлогод тооцсон хураамж	Нийт нөхөн төлбөрийн зардал	Үйл ажиллагааны зардал	Хохирлын харьцаа	Хосолсон харьцаа
1	Монре даатгал	1,315.3	328.1	1,107.3	24.9%	109.1%
2	Ард даатгал	9,215.3	5,353.5	4,482.8	58.1%	106.7%
3	Бодь даатгал	5,733.7	2,398.3	3,590.0	41.8%	104.4%
4	Мөнх даатгал	5,087.2	2,263.6	2,983.4	44.5%	103.1%
5	Миг даатгал	12,353.4	5,678.7	6,849.1	46.0%	101.4%
6	Монгол даатгал	4,317.4	2,100.3	3,129.6	48.6%	121.1%
7	Тэнгэр даатгал	4,885.4	1,346.1	3,270.3	27.6%	94.5%
8	Номин даатгал	3,745.9	2,499.3	2,363.0	66.7%	129.8%
9	Улаанбаатар хотын даатгал	2,966.0	1,747.9	1,344.0	58.9%	104.2%
10	Амар даатгал	4,262.3	1,330.0	2,401.1	31.2%	87.5%
11	Ган зам даатгал	309.2	15.3	134.8	4.9%	48.5%
12	Практикал даатгал	5,137.6	13,044.7	2,903.0	253.9%	310.4%
13	Мандал даатгал	10,109.2	5,918.4	4,449.2	58.5%	102.6%
14	Хаан даатгал	6,902.9	3,458.4	2,779.1	50.1%	90.4%
15	Агула даатгал	1,378.0	467.1	871.2	33.9%	97.1%
16	Иншүрко даатгал	185.1	5.4	319.0	2.9%	175.3%
17	Агис менежмент даатгал	25.4	11.5	267.5	45.2%	1099.7%
НИЙТ		77,929.3	47,966.7	43,244.4	61.6%	117.0%
Урт хугацааны даатгал						

№	Даатгалын компани	Даатгалын цэвэр хураамжийн орлого	Нийт төлсөн нэхэмжлэл	Үйл ажиллагааны зардлын дүн	Хохирлын харьцаа	Хосолсон харьцаа
1	Нэйшнл лайф даатгал	947.3	555.1	555.0	58.6%	117.2%
2	Мандал лайф даатгал	581.2	600.0	318.0	103.2%	157.9%
НИЙТ		1,528.5	1,155.1	873.0	75.6%	132.7%
Давхар даатгалын компани						
1	Үндэсний давхар даатгал	65.0	104.5	1,328.0	160.7%	2202.9%

2.8. АШИГТ АЖИЛЛАГАА



14.4 тэрбум төгрөгт хүрсэн нь өмнөх мөн үетэй харьцуулахад **72.4 хувиар** өссөн байна.

Ердийн даатгалын компаниудын цэвэр ашгийн хэмжээ 2025 оны 1 дүгээр улиралд 10.3 тэрбум төгрөгт хүрсэн бол, урт хугацааны даатгалын компаниуд 5.4 сая төгрөгийн цэвэр ашигтай ажилласан нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 95.0 хувиар, мөн давхар даатгалын компани 4.1 тэрбум төгрөгийн цэвэр ашигтай ажилласан нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 5.7 хувиар тус тус буурсан байна. Нийт даатгагчдын ашигт ажиллагаа 14.4 тэрбум төгрөгт хүрсэн нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 72.4 хувиар өссөн байна. /Хүснэгт №11-д дэлгэрэнгүй харуулав

/Хүснэгт №11. Даатгагчийн ашигт ажиллагаа /сая.төг/

№	Даатгалын компани	2021.I	2022.I	2023.I	2024.I	2025.I	Ө/Б 2024.I-2025.I
Ердийн даатгалын компани							
1	Монре даатгал	453.7	92.6	168.1	28.5	1,622.6	5585.3%
2	Ард даатгал	6,671.5	51.6	406.5	89.3	35.2	-60.6%
3	Бодь даатгал	500.4	-769.3.	-350.9.	345.1	683.1	98.0%
4	Мөнх даатгал	66.5	12.4	190.6	18.7	67.3	260.2%
5	Миг даатгал	121.6	80.4	115.1	193.5	1,230.3	535.8%
6	Монгол даатгал	556.1	106.8	341.8	-850.0	-186.9	-78.0%
7	Тэнгэр даатгал	499.0	463.9	910.8	1,201.6	1,138.2	-5.3%
8	Номин даатгал	-272.9.	0.0	151.8	-222.3	-143.4	-35.5%
9	Улаанбаатар хотын даатгал	419.0	480.3	6.4	-963.7	-61.1	-93.7%
10	Амар даатгал	449.2	370.4	224.2	689.0	1,414.9	105.4%
11	Ган зам даатгал	191.6	131.3	186.1	327.8	363.8	11.0%

21 | Даатгалын салбарын 2025 оны 1 дүгээр улирлын үйл ажиллагааны нэгдсэн тайлан

12	Практикал даатгал	768.2	145.2	-912.1.	1,092.6	1,186.9	8.6%
13	Мандал даатгал	1,744.8	1,049.5	875.2	1,820.7	1,609.6	-11.6%
14	Хаан даатгал	294.1	244.2	903.2	256.6	1,630.0	535.3%
15	Агула даатгал		124.5	-853.5.	-146.7	-129.1	-12.0%
16	Иншүрко даатгал				34.8	-7.4	-
17	Агис менежмент даатгал					-125.2	-
Нийт		12,462.7	2,583.9	2,363.4	3,915.5	10,328.8	163.8%
Урт хугацааны даатгалын компани							
1	Нэйшнл лайф даатгал	52.0	48.5	15.5	-36.0	-36.6	1.5%
2	Мандал лайф даатгал			52.2	143.1	41.9	-70.7%
Нийт		52.0	48.5	67.6	107.1	5.4	-95.0%
Давхар даатгалын компани							
1	Үндэсний давхар даатгал	551.5	753.9	1,291.8	4,353.5	4,103.4	-5.7%
Нийт		551.5	753.9	1,291.8	4,353.5	4,103.4	-5.7%
Бүх даатгагчдын нийт дүн		13,066.1	3,386.3	3,722.8	8,376.0	14,437.5	72.4%

2.8. ДАВХАР ДААТГАЛ



Давхар даатгалын хураамж **26.5** тэрбум төгрөг, үүнээс дотоодын давхар даатгагчид **2.0** тэрбум төгрөг

Тайлант хугацаанд ердийн болон урт хугацааны даатгалын компаниуд нийт 26.5 тэрбум төгрөгийн давхар даатгалын хураамж төлсний 7.6 хувь буюу 2.0 тэрбум төгрөгийг дотоодын давхар даатгагчид төлсөн байна. “Бодь даатгал” ХК нь агаарын хөлгийн даатгалын хэлбэрийн хувьд хамгийн их буюу 10.7 тэрбум төгрөгийн давхар даатгалын хураамжийн зардалтай ажилласан байна. Энэ нь нийт давхар даатгалын хураамжийн зардлын 40.2 хувийг эзэлж байна. /Хүснэгт №12-д дэлгэрэнгүй харуулав/

Хүснэгт №12. Давхар даатгалын хураамж

Давхар даатгалын хураамжийн зардал /сая.төг/						
№	Даатгалын компани	2021.I	2022.I	2023.I	2024.I	2025.I
Ердийн даатгал						
1	Монре даатгал	4.2	9.2	0.0	560.0	760.9
2	Ард даатгал	40.6	1,004.4	1,320.1	675.5	623.4
3	Бодь даатгал	1,564.3	860.7	395.7	1,700.2	10,660.5
4	Мөнх даатгал	427.5	8.1	186.1	446.5	1,149.3
5	Миг даатгал	1,264.0	741.0	363.8	521.4	812.1
6	Монгол даатгал	1,530.6	613.0	1,107.6	835.3	1,048.9

22 | Даатгалын салбарын 2025 оны 1 дүгээр улирлын үйл ажиллагааны нэгдсэн тайлан

7	Тэнгэр даатгал	1,148.2	1,084.3	687.7	508.3	1,009.3
8	Номин даатгал	51.5	244.2	250.1	1,290.0	456.6
9	Улаанбаатар хотын даатгал	0.0	0.0	0.0	23.1	0.0
10	Амар даатгал	159.7	1,732.2	5,195.3	4,140.4	1,551.1
11	Ган зам даатгал	0.0	0.0	0.0	0.0	0.0
12	Практикал даатгал	14.3	1,116.9	5,009.0	9,968.8	1,258.8
13	Мандал даатгал	4,712.7	4,559.0	6,865.2	12,039.3	2,804.6
14	Хаан даатгал	0.0	166.9	268.9	689.5	3,713.8
15	Агула даатгал		66.8	212.0	1,783.2	505.2
16	Иншүрко даатгал					111.3
17	Агис менежмент даатгал					0.0
Нийт		10,917.5	12,206.7	21,861.4	35,181.3	26,466.0
Урт хугацааны даатгал						
1	Нэйшнл лайф даатгал	5.8	6.2	11.3	13.4	7.7
2	Мандал лайф даатгал			0.0	2.7	29.6
Нийт		5.8	6.2	11.3	16.0	37.3
Давхар даатгал						
1	Үндэсний давхар даатгал	739.7	799.8	1,266.4	1,829.0	1,951.4
Бүх даатгагчдын нийт дүн		11,663.0	13,012.6	23,139.2	37,026.3	28,454.7

3. ЕРДИЙН ДААТГАЛ

3.1. ЕРДИЙН ДААТГАГЧДЫН ХӨРӨНГӨ



Ердийн даатгагчдын хөрөнгө **591.1** тэрбум төгрөгт хүрч өмнөх оноос **19.0%**-аар өссөн байна.


Тайлант хугацаанд ердийн даатгагчдын нийт хөрөнгө 591.0 тэрбум төгрөг байгаагаас хамгийн их хувийг буюу 16.8 хувийг “Мандал даатгал” ХК, 10.3 хувийг “Миг даатгал” ХХК, 9.8 хувийг тус тус “Бодь даатгал” ХК, “Тэнгэр даатгал” ХК-ийн нийт хөрөнгө эзэлж байна. /Хүснэгт №13-д дэлгэрэнгүй харуулав /

Хүснэгт №13. Ердийн даатгагчдын хөрөнгө ангилал тус бүрээр /сая.төг/

№	Даатгалын компани	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн дүн	Даатгалын авлагын дүн	Хөрөнгө оруулалтын дүн	Нийт хөрөнгийн дүн	Эзлэх хувь
1	Монре даатгал	18.4	1,542.7	6,264.8	14,895.5	2.5%
2	Ард даатгал	451.6	4,865.0	30,418.8	48,703.8	8.2%
3	Бодь даатгал	1,344.3	10,625.5	21,959.5	57,717.0	9.8%
4	Мөнх даатгал	2,007.2	2,260.1	9,153.3	25,209.9	4.3%
5	Миг даатгал	2,465.1	8,666.3	37,686.1	61,154.2	10.3%
6	Монгол даатгал	834.2	1,022.3	10,414.5	27,290.7	4.6%
7	Тэнгэр даатгал	474.2	842.0	49,641.2	57,988.2	9.8%
8	Номин даатгал	239.4	105.0	24,256.7	27,248.0	4.6%
9	Улаанбаатар хотын даатгал	798.6	719.7	4,594.7	11,898.5	2.0%
10	Амар даатгал	2,815.0	4,926.6	19,557.0	32,803.9	5.5%
11	Ган зам даатгал	213.2	612.1	6,855.2	7,707.7	1.3%
12	Практикал даатгал	276.7	3,071.1	24,338.4	41,760.6	7.1%
13	Мандал даатгал	1,002.9	2,928.5	65,536.0	99,172.7	16.8%
14	Хаан даатгал	4,771.4	6,520.3	17,043.8	54,464.1	9.2%
15	Агула даатгал	133.8	565.0	2,565.2	10,559.8	1.8%
16	Иншүрко даатгал	1,205.0	598.5	4,169.5	6,619.6	1.1%
17	Агис менежмент даатгал	707.9	12.7	5,065.3	5,875.3	1.0%
	Нийт	19,758.8	49,883.3	339,520.0	591,069.3	100.0%

Ердийн даатгагчдын хөрөнгийн 57.4 хувь буюу 339.5 тэрбум төгрөг нь хөрөнгө оруулалт хэлбэрээр байршиж байгаа бөгөөд үүнээс 25.6 хувь буюу 86.9 тэрбум төгрөгөөр үнэт цаасанд хөрөнгө оруулсан байна. /Дүрслэл №13-т дэлгэрэнгүй харуулав /

Дүрслэл №13. Ердийн даатгагчдын хөрөнгийн ангилал /эзлэх хувиар/



3.2. ЕРДИЙН ДААТГАГЧДЫН ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧИЙН ДҮН

Тайлант хугацаанд ердийн даатгагчдын нийт өр төлбөрийн дүн 360.7 тэрбум төгрөг, нөөц сангийн дүн 285.6 тэрбум төгрөгт хүрсэн байна. Хамгийн өндөр дүн бүхий 5 даатгалын компани (“Мандал даатгал” ХК, “Хаан даатгал” ХХК, “Миг даатгал” ХХК, “Бодь даатгал” ХК, “Ард даатгал” ХХК)-ийн нөөц сангийн дүн ердийн даатгалын нийт нөөц сангийн дүнгийн 61.0 хувийг эзэлж байна. /Хүснэгт №14-д дэлгэрэнгүй харуулав/

Хүснэгт №14. Ердийн даатгагчдын өр төлбөр ба эздийн өмчийн дүн /сая.төг/

№	Даатгалын компани	Нөөц сангийн дүн	Нийт өр төлбөрийн дүн	Эздийн өмчийн дүн	Нийт өр төлбөр ба эздийн өмчийн дүн	Эзлэх хувь
1	Монре даатгал	3,784.7	12,003.3	2,892.2	14,895.5	2.5%
2	Ард даатгал	25,388.5	31,149.5	17,554.3	48,703.8	8.2%
3	Бодь даатгал	32,817.6	44,736.4	12,980.6	57,717.0	9.8%
4	Мөнх даатгал	12,896.8	14,846.4	10,363.5	25,209.9	4.3%
5	Миг даатгал	33,089.8	47,144.1	14,010.1	61,154.2	10.3%
6	Монгол даатгал	15,394.2	18,625.4	8,665.3	27,290.7	4.6%
